



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтэд хийгдэж буй хяналт-шинжилгээ үнэлгээний зорилго нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлэхэд оршино.

Хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын хүрээнд үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан мэдээлэл, түүнийг нотлож буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ үнэлгээг хийсэн бөгөөд үндсэн чиглэл төлөвлөгөөг орон нутагт чанартай, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлага болоод Засгийн газрын Хэрэг эрхлэх газрыг үнэн зөв мэдээллээр хангах үндсэн чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолийн хавсралтаар баталсан **“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**-д заасан үнэлгээ хийх аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2019 оны ажлын төлөвлөгөөний дагуу удирдамж гарган 21 хэлтэс, газар, 15 сумдаар явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний

Засаглалын хүрээний 24 арга хэмжээ

Эдийн засгийн хүрээний 8 арга хэмжээ

Нийгмийн бодлогын хүрээний 17 арга хэмжээ

Хүнс, хөдөө аж ахуй газар тариалан үйлдвэрлэлийн хүрээний 16 арга хэмжээ,

Байгаль орчин аялал жуулчлал, уул уурхайн хүрээний 8 арга хэмжээ,

Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээний 18 арга хэмжээ, нийт 90 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний биелэлтэд 12 сарын 27-ны байдлаар үнэлгээ хийхэд 92,3 % хэрэгжилттэй байна.

- Бүрэн хэрэгжсэн 67 заалт арга хэмжээ нь нийт арга хэмжээний 74,4 хувийг,

-Хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай хэрэгжиж байгаа 12 заалт арга хэмжээ нь 13,4 %-ийг,

-Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай хэрэгжсэн 3 заалт арга хэмжээ нь 3,3 %-ийг,

-Хэрэгжээгүй буюу 0 хувьтай 1 арга хэмжээ нь нийт заалтын 1,1 хувийг,

-Хугацаа болоогүй 7 арга хэмжээ нь 7,8 хувийг тус тус эзэлсэн байна.

ДУНГОВЬ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО


№	Агуулга	Нийт арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Үүнээс				Нийт хувь
				70	40	0	Үнэлэх боломжгүй	
1	ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД	24	20	3	-	-	1	96
2	ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД	8	5	3	-	-	-	88,8
3	НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД	17	15	-	1	-	1	96,2
4	ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД	16	11	4	-	-	1	92
5	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД	7	6	1	-	-	-	95,7
6	БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД	18	10	1	2	1	4	82,1
	Дүн	90	67	12	3	1	7	92,3

Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад эхний 5 сарын байдлаар үнэлгээ хийхэд 65,8 хувийн биелэлттэй хэрэгжиж байсан.



Холбогдох төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс Аймгийн Засаг даргын Тамгын газраас дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан удирдамжийн дагуу 21 хэлтэс, газар, 15 сумдаар явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Сумдын болон хэлтэс агентлагийн жилийн эцсийн ажлыг дүгнэх үзүүлэлтэд Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний тухайн байгууллагад хамааралтай заалтын биелэлтийг хамааруулан тооцож дүгнэсэн нь аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ахиц өөрчлөлт гарахад түлхэц боллоо. Төлөвлөгөөний хэрэгжилтэд 11 сарын 10-ны байдлаар явцын үнэлгээ хийж 85,2 хувьтай хэрэгжилтийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2019 оны 12 сарын 4-ний 10 дугаар хурлаар хэлэлцүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой тооцоход анхаарах, эрчимжүүлж ажиллах чиглэлээр зөвлөмж өгч, дараа оны хурлаар дүгнүүлэхийг чиглэл болголоо.



Цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж

Аймгийн түвшинд:

1. Хэлтсийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд нь өөрт хамааралтай арга хэмжээг хяналтад шуурхай авч, “Дэд хөтөлбөр, бодлого, стратеги”-ийг боловсруулан, хэлэлцүүлж батлуулах ажлыг шуурхай, төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж хариуцан ажиллах
2. Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөр, бусад бодлогын баримт бичгийг үндсэн чиглэл төлөвлөгөөнд тусгах болон санхүүгийн асуудал шийдвэрлэхийг даалгасан шийдвэрийг эртнээс хэрэгжүүлэн ажиллах
3. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар харуулахуйцаар баримтжуулан тайлагнаж хэвших

4. Хугацаа болоогүй болон удаашралтай хэрэгжиж байгаа арга хэмжээг нэн даруй судалж хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөө гарган биелэлтийг тооцож зохион байгуулах

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС